"ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЛТАН ҮЕ-3"

# ТӨСЛИЙН УДИРДАМЖ

## НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйлс болсон **"Үйлдвэрлэлийн Алтан Үе"** бий болгоход жижиг дунд үйлдвэрлэгчдэд шинэ бизнесийн санаа олоход туслах зорилгоор их дээд сургуулийн 3,4-р курсын оюутнуудийн бизнес сэтгэлгээг хөгжүүлэх, шаардлага хангасан төслүүдийг санхүүжүүлж, үйл ажиллагааг дэмжих замаар аж ахуй эрхлэх ур чадварыг олгох, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд төслийн голзорилгооршино.

Ихэнх эрдэмтэд оюутан насандаа шинэ нээлт хийх үндэс сууриа тавьсан байдаг билээ үүнтэй адил бид монголд байгаа нийт оюунлаг оюутан залуусаа үйлдвэрлэлийн алтан үеийн эзэд хэмээн бодож байна.

Уг хөтөл бөрт их, дээд сургуулиудын оюутан залуус оролцож өөрсдийн төслөө хэрэгжүүлж улмаар зорилго мөрөөдлөө биелүүлж олон олон ажлын байр бий болгож санхүүгийн эрх чөлөөнд хүрэх боломжийг олгох юм.

## ХОЁР.ТӨСЛИЙГ ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

**Төслийн шалгаруулалт 3 үешаттайгаарзохионбайгуулагдана.**

1. Оролцох багууд бизнесийн төлөвлөгөө гаргаж танилцуулна. Энэ үе шатанд мэргэжлийн хүмүүс үнэлгээ өгч дүгнэнэ. Нэгдүгээр үеэс хасагдах журмаар явна.

2. Нэгдүгээр үеэс шалгарсан багууд төсөл бичнэ. Шилдэг санаатай дэмжигдэх боломжтой төслүүдийг шалгаруулна.

3. Шалгарч үлдсэн төслүүдэд мэргэжлийн хүмүүс зөвлөгөө өгнө. Төслүүдийг зөвлөгөөний дагуу хэрхэн төслөө сайжруулсан байдлаар дахин шалгаруулт хийнэ. Ижил төстэй одоо хэрэгжиж байгаа жижиг дунд үйлдвэр эрхлэгчидтэй уулзаж санал солилцоно.

4.Шалгарсан төслийн багтай мэргэжлийн хүмүүс орж ажиллана. Сайжруулсан төслийг дахин шалгаруулж, шилдгийн шилдэг 3-4 төсөл шалгаруулна.

Хөтөлбөрийн шалгаруулалтанд оролцох багуудыг 2013 оны04-р сарын 01 өдрөөс 15-н хүртэл ажлын цагт бүртгэнэ.

Хаяг:ТВ5 телевизийн байранд бүртгэнэ.

2013.04.08-нд ирсэн. 99339554

## ГУРАВ. ТӨСӨЛ, ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шалгаруулалтанд ирүүлэх төсөл, төлөвлөгөөнд тавигдах шаардлага:

- Шалгаруулалтанд оролцогчид нь их дээд сургуулийн оюутнууд байна. (Багийн гишүүд өөр мэргэжилийн оюутан байвал давуу тал болно.)
- Төсөл, төлөвлөгөө нь хэрэгжих бүрэн үндэслэлтэй, судалгаа шинжилгээгээр баталгаажсан байна
- Уг төсөл, төлөвлөгөөг оюутнууд өөрсдөө бичсэн байна.
- Жижиг дунд үйлдвэрлэлийн газрын 2013 оны зорилттой уялдсан байна.
- Монгол оронд байгаа түүхий эд, нөөцөд тулгуурлаж бичсэн бол давуу тал болно.
- Төсөлдөө гадаадын улс орнуудад хэрэгжиж буй жишээ дурьдсан байж болно.
- Баг бүр 3-4 оюутнаас бүрдэнэ.

## ДӨРӨВ. БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

**Бүртгүүлэхээр ирэхдээ дараах зүйлүүдийг бүрдүүлсэн байна.Үүнд:**

- Бизнесийн төсөл,төлөвлөгөө (хэвлэмэл байдлаар)
- Багтаа оноосон нэр
- Оролцох багуудын товч танилцуулга
- Холбоо барих хаяг, утасны дугаараа үнэн зөв бичнэ.
- Сургуулиас албан бичиг ( ТВ5 телевизийн үйлдвэрлэлийн алтан үе нэвтрүүлэгт оролцох хүсэлт)

## ТАВ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

**1 байр:**

Багийн гишүүн бүрт нөөтбүүк

Ажлын байранд орох эрх

Ивээн тэтгэгчийн шагнал

**2 байр:**

Багаараа Хөвсгөл далайд аялах эрх

Ивээн тэтгэгчийн шагнал

**3 байр**

1 сая төгрөг

Ивээн тэтгэгчийн шагнал